

**“НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ХЭМЖЭЭНД
2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАДАНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ
4 ДҮГЭЭР УЛИРЛЫН БИЕЛЭЛТИЙН МЭДЭЭ**

2020.12.25


Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Төлөвлөгөөний биелэлт	Хэрэгжилтийн хувь	
1	2	3	4	5	6	
1	Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, чадварын болон ерөнхий тусгай шалгуурыг үндэслэн дэвшүүлэн томилно.	Сул орон тооны зар, сонгон шалгаруулалтын талаарх мэдээлэл, харилцах утасны дугаар зэргийг цахим хуудас болон мэдээллийн самбарт иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлэх	I, II, III, IV улирал	Сул ажлын байрны зар, холбогдох утасны дугаар, хаягийн мэдээллийг www.khangardi.mn цахим хуудас болон байгууллагын ил тод байдлын самбарт нээлттэйгээр, 14 хоногийн давтамжтайгаар шинэчлэн байршуулж байна. Мөн www.ulevdi.mn -д цахим хуудас болон дүүргүүдийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсээр дамжуулан 6 төрлийн ажлын байранд 6 удаагийн давтамжтай захиалга өгч ажиллагаа. Зарын дагуу ирсэн ажил горилгогчдоос сонгон шалгаруулалт хийх байдлаар ажлын байрны сул орон тоог нөхөж ажиллаж буй бөгөөд тодорхой ур чадвар, туршлага шаардсан ажлын байранд албан хаагч сонгон шалгаруулахдаа мөрийг зарчмыг удирдлага болгон ажилласнаар тайлант хугацаанд 5 ажилтан, албан хаагчийг дэвшүүлэн томилсон байна.	Байгууллагын мэргэжлийн албан хаагчийн сул орон тоог нөхөхдөө Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан чадахуйн /мерит/ болон шатлан дэвшүүлэх зарчмыг удирдлага болгон ажилласнаас тайлант хугацаанд утгах үйлчилгээний ажилтан А.Нямсүрэн, Ц.Батсайхан нарыг байр харууцсан менежерээр, бичиг хүргэгч С.Эрдэнэбулган, үйлчлэгч Ц.Батчимэг нарыг утгах үйлчилгээний ажилтнаар, үйлчлэгч С.Данжмааг угаачаар тус тус дэвшүүлэн томилсон.	100%


1	2	3	4	5	6
	<p>Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг олон эх үүсвэрээр хүлээн авч, шийдвэрлэлтийн хугацааг богиносгох</p> <p>Коронавируст /КОВИД-19/ халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд албан тушаалтны гаргаж буй шийдвэр, байгуулж буй гэрээ хэлцэл нь авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж ажиллах</p>	<p>Авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг олон эх үүсвэрээр хүлээн авч, шийдвэрлэлтийн хугацааг богиносгох</p> <p>Коронавируст /КОВИД-19/ халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд албан тушаалтны гаргаж буй шийдвэр, байгуулж буй гэрээ хэлцэл нь авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж ажиллах</p>	<p>I, II, III, IV улирал</p>	<p>Тайлант хугацаанд авлига, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай болон уг асуудалтай холбогдуулан гарсан ёс зүйн зөрчлийн талаар өргөдөл гомдол байгууллагад ирээгүй болно.</p> <p>Коронавируст /КОВИД-19/ халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд албан тушаалтны гаргаж буй шийдвэр, гуравдагч этгээдтэй байгуулж буй гэрээ хэлцэл нь аливаа байдлаар авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлж, шат дамжлагатайгаар хянаж баталгаажуулж байна.</p>	<p>100%</p>
2	<p>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчдад зориулсан Авлигын эсрэг сургалт, давтан сургалт зохион байгуулна.</p>	<p>Эрх бүхий албан тушаалтан, мэдүүлэг гаргагч нарт зориулсан идэвхтэй хамрагдах</p>	<p>III, IV улирал</p>	<p>Засгийн газрын 62, 178, 226 дугаар тогтоолоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хатуу хөл хорио тогтоон, олон нийтийг хамарсан аливаа сургалт, үйл ажиллагаа зохион байгуулахыг хориглосонтой холбоотойгоор энэ онд эрх бүхий байгууллагаас жил бүр зохиогддог авлигын эсрэг сургалтыг түр завсарласан болно.</p>	<p>Үнэлэх боломжгүй</p>
3	<p>Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулна.</p>	<p>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагад ажиллаж буй төрийн албан хаагчид болон байгууллагын ажилтан, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийг олон эх үүсвэрээр хүлээн авч, шуурхай шийдвэрлэх.</p>	<p>I, II, III, IV улирал</p>	<p>Байгууллагын хэмжээнд ажилтан, албан хаагчид, иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг тухай бүр бүртгэлийн системд байршуулан, шийдвэрлэлтийн явцыг ил тод, шуурхай байлгах зорилгоор явцын тэмдэглэлийг хуанлийн 10 хоног бүр хөтлөн ажиллаж байна. Мөн ажилтан, албан хаагчдаас хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар ирсэн өргөдлийг холбогдох ажилтан бүртгэж удирдлагад шилжүүлэн, удирдлагаас хариуцсан албан хаагчид шийдвэрлэх чиглэл өгч шилжүүлснээр 2 удаагийн шат дамжлагатайгаар</p>	<p>100%</p>
4					

1	2	3	4	5	6
				<p>Шийдвэрлэж байгаа болно. Тайлант хугацаанд 4 үндсэн эх үсвэрээр нийт 81 өргөдөл ирснийг бүрэн шийдвэрлэж, хариуг холбогдох этгээдэд биечлэн хургүүлсэн ба мөн хугацаанд өргөдөл гомдлын шийдвэрлэлттэй холбоотой зөрчил гараагүй, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног 9 цаг 20 минут байгаа нь өмнөх улирлаас тогтмол буурсан үзүүлэлттэй байна.</p>	
5	<p>Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан дүрст сурталчилгааг хийнэ.</p>	<p>Авлигын эсрэг хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагаас авлигын эсрэг зохион байгуулж буй арга хэмжээ, үйл ажиллагааг байгууллагын цахим хуудас бүсэд мэдээллийн эх үүсвэрээр нийтэд сурталчлах</p>	<p>I, II, III, IV улирал</p>	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан, энэ чиглэлийн мэдээ мэдээллийг байгууллагын www.khangardi.mn цахим хуудас, "Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар" гэйж хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байршуулан ажиллаж байна. Мөн Авлигатай тэмцэх газраас гаргасан албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах, түүнтэй танилцах, мэдээлэл өгөх тухай зөвлөмж бүхий шторкийг байгууллагын вэб хуудас, фэсбейүүк хуудсанд тус тус байршуулан, олон нийтэд сурталчлах ажлыг идэвх санаачилгатай зохион байгуулж ажиллагаа.</p>	<p>100%</p>

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН
БАЙГУУЛЛАГЫН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

 Ч.ШИНЭЧИМЭГ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН

 Э.ХОРОЛДУЛАМ